



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДУУРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 10 сарын 08 өдөр


Дугаар 1/38

Улаанбаатар хот

Г Журам батлах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1, Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 05 дугаар тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн ажилтанд улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллыг хавсралтаар баталсугай.
2. Ажилчдын ажлын үр дүнг зохих журмын дагуу дүгнэж урамшуулах ажлыг чанартай зохион байгуулж ажиллахыг байгууллагын удирдлагын багийн гишүүдэд үүрэг болгосугай.
3. Ажилчдын ажлын үр дүнг тооцож хурлын бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг Хүний нөөцийн ажилтан /Г.Гантуяа/-д үүрэг болгосугай.



Багахангай Эрүүл мэндийн төвийн даргын
2020 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн
11:38 дугаар тушаалын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТАНД УЛИРЛЫН АЖЛЫН ҮР ДҮНГЭЭР ОЛГОХ МӨНГӨН УРАМШУУЛАЛ

1. Эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа ажилтандаа ажлын үр дүн, гүйцэтгэлийг нь үндэслэн мөнгөн урамшуулал олгоно.

2. Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үндэслэн үндсэн цалингийн 10-20 хувиар сар бүр тооцож, улирал тутам олгоно. (Энэ дэд заалтад Засгийн газрын 2019 оны 395 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)

3. Эрүүл мэндийн байгууллага нь эрүүл мэндийн ажилтандаа мөнгөн урамшуулал олгоходоо энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийг баримтлан ажлын үр дүн, гүйцэтгэлийг дүгнэж, тухайн жилийн төсөвт уг урамшуулалд зориулан батлагдсан хөрөнгийн дүнд багтаан энэ журмын 10, 12-т заасан шийдвэрийг үндэслэн олгоно.

4. Мөнгөн урамшуулал олгоход дараахь шалгуур үзүүлэлтийг баримтална:

Албан тушаал	Үр дүнгийн үндсэн шалгуур	Үндсэн шалгуурыг тодорхойлох тусгай үзүүлэлт
А. Эрүүл мэндийн ажилтандаа тавигдах нийтлэг шалгуур үзүүлэлт		
Эрүүл мэндийн ажилтан	Үйлчилгээний чанар	1. Үйлчлүүлэгчдэд эмнэлгийн тусlamж үйлчилгээг үзүүлэхдээ хүлээлгэж чирэгдүүлэлгүй үүсгэхгүйгээр тусlamж үйлчилгээ үзүүлсэн байдал /үүнд яаралтай тусlamж, амбулатори, хэвтэн эмчлүүлэгч бүгд хамаарна/ /10/
	Ажлын ачаалал, хариуцлага	1. Ажлын цагийн хоцрогдол, ажлын цаг ашиглалт - 10 2. Хариуцсан өмч хөрөнгийн ашиглалт - /5/ 3. Албан хэргийн бүртгэл, хөтлөлт, тайланг хугацаанд нь гаргасан байдал - Ажлын байранд хөтлөгджэж байгаа бичиг баримтыг бүрэн хөтөлж байгаа эсэх, баримт бичгийн бүрдлийг албан хэрэг хэрэг хөтлөлтийн стандартынг баримталж байгаа эсэх, хугацаатай бичгийн шийдвэрлэлтийг хамрааруулан тооцно. /20/ 4. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт -10 5. Тайлан мэдээг цаг хугацаанд нь гаргаж

		тайлагнасан байдал -10
Эмнэлгийн тусlamж, үйлчилгээнд оруулсан хувь нэмэр		<ol style="list-style-type: none"> 1. Эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр санаачилж хийсэн ажил -10 2. Тусlamж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд зохион байгуулж байгаа ажилд оролцож байгаа байдал, 3. Олон нийтийг хамарсан арга хэмжээнд оролцсон байдал.-10 4. Бэлэн байдлыг хангаж ажилласан эсэх -10

Б.Тусгай шалгуур үзүүлэлт

Эмнэлгийн мэргэжилтэн	Эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанар	<ol style="list-style-type: none"> 1. Тусlamж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эмчилгээ оношлогооны түгээмэл үйлдэл, стандартыг баримталж мөрдөж ажиллаж байгаа эсэх, үйлчлүүлэгчдэд үзүүлж байгаа тусlamж үйлчилгээ чанар-20 2. Халдварт хамгааллын дэглэмийг баримталж ажиллаж байгаа эсэх, хувцаслалтыг бүрэн өмссөн байдал -10 3. Эмчилгээ, үйлчилгээний талаар гаргасан гомдол-10 4. Үйлчлүүлэгчид зөвлөгөө өгсөн байдал-10 5. Албан тушаалтны тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэл, чанар -10
Эрүүл мэндийн бусад ажилтан	Хариуцсан чанар ажлын	<ol style="list-style-type: none"> 1. Ажлын байранд мөрдөгдөх стандарт мөрдөж байгаа байдал-10 2. Албан тушаалтны тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэл, чанар -10 3. Халдварт хамгааллын дэглэмийг баримталж ажиллаж байгаа эсэх, хувцаслалтыг бүрэн өмссөн байдал -10
Мэдлэг чадварын үнэлгээ	Мэдлэг чадвараа дээшлүүлэх	<ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын дотоодын сургалтын хамрагдсан байдал /5/ 2. Холбогдох байгууллагын сургалтанд хамрагдаж ирээд байгууллагын хэмжээнд сургалт зохион байгуулсан эсэх /5/ 3. Сургалтын үр дүн байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх талаарх зохион байгуулсан арга хэмжээ /5/

5. Эрүүл мэндийн ажилтны албан тушаалын тодорхойлолтод тусгасан үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийг дүгнэх журам, энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийг тооцох аргачлалыг дагуу байгууллагын удирдлагын багийн гишүүд үнэлж байгууллагын даргын шийдвэрээр батална.

6. Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг "бүрэн хангалттай", "хангалттай" гэж үнэлж, улирал бүр дүгнэнэ.

7. Ажлын үр дүнгийн үнэлгээнээс хамааран дараах хувь хэмжээгээр сар бүр мөнгөн урамшуулал тооцно:

Бүх шалгуурын биелэлтийн хувь	Ажлын үр дүнгийн үнэлгээ	Албан тушаалын үндсэн цалингаас урамшил тооцох хувь (сард)
90-100	Бүрэн хангалттай	11-20 хувь 100%-95% үнэлгээ үндсэн цалингийн 20% 94%-90% үнэлгээ үндсэн цалингийн 15%
71-89	хангалттай	10 хувь хуртэл 89%-85% үнэлгээ үндсэн цалингийн 10% 84%-80% үнэлгээ үндсэн цалингийн 9% 79%-75% үнэлгээ үндсэн цалингийн 7% 74%-71% үнэлгээ үндсэн цалингийн 5%

8. Ажлын үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлт 71-ээс доош хувьтай байгаа тохиолдолд тухайн албан хаагчид улирлын урамшуулал олгохгүй.

9. Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг байгууллагын удирдлагын багийн гишүүдийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт гаргана.

10. Эрүүл мэндийн байгууллагын удирдлагын багийн гишүүдийн хурлаас гаргасан дүгнэлтийг үндэслэн эрүүл мэндийн ажилтанд мөнгөн урамшил олгох шийдвэрийг байгууллагын дарга гаргана.

11. Мөнгөн урамшууллыг дараа улирлын эхний сарын 15-ны дотор олгоно.

12. Эрүүл мэндийн байгууллагын даргын ажлын үр дүнг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар болон тухайн албан тушаалтныг томилсон эрх бүхий албан тушаалтан дүгнэж, шийдвэр гаргана.